



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№67 /281/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.04.06

Цаг үе, үйл явдал

## “МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ АЧ ХОЛБОГДОЛ” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг угтаж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн хамтран “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангахад энхийг дэмжих ажиллагааны ач холбогдол” сэдэв эрдэм шинжилгээний хурлыг өнөөдөр зохион байгуулж байна. Тус хуралд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөл, дэслэгч генерал Ц.Тогоо, Батлан хамгаалахын дэд

сайд Б.Баярмагнай, ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, ҮАБЗ-ийн ажлын албаны дарга бригадын генерал Д.Ариунболд, ҮБХИС-ийн захирал бригадын генерал П.Жаргалан БХЯ, ЗХЖШ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, ҮАБЗ, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлага, энхийг сахиулагчдын төлөөлөл оролцлоо. “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангахад энхийг дэмжих ажиллагааны ач холбогдол” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд энхийг дэмжих ажиллагааны үзүүлсэн нөлөөлөл, ач холбогдол”, “Монгол

Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах шаардлага, улс төрийн шийдвэр”, “Монгол Улсын Зэвсэгт хүчнийг НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах бэлтгэл ажил, сорил, бэрхшээл”, “НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа: Монгол Улсын Зэвсэгт хүчний оролцоо”, “Монгол Улсын батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаанд энхийг дэмжих ажиллагааны оруулж буй хувь нэмэр”, “Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг хөгжүүлэхэд энхийг дэмжих ажиллагааны үүрэг, ач холбогдол”, “Монгол Улсын гадаад бодлогод энхийг дэмжих ажиллагааны үүрэг, ач холбогдол” зэрэг үндсэн болон хавсралт илтгэлүүдийг хэлэлцлээ.



### ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 13	☁️ -4
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 40	☁️ 25

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,080.00	3,150.0
EUR	3,530.0	3,580.0
CNY	496.00	499.00
RUB	36.00	36.80
JPY	26.00	27.50
KRW	2.60	2.69

### ЗУРХАЙ

2022.04.06 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 5/

**ХАВРЫН АДАГ ХӨХ ЛУУ САРЫН ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ҮХЭР ӨДӨР**

**Үс засуулбал:**  
Эд, мал арвижна  
**Наран ургах, шингэх:**  
06.21-19.28  
**Барилдлага:**  
Идэр  
**Шүтэн барилдлага:**  
Хурьцахуй  
**Суудал:** Уул

Энэ өдөр тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, мал арилжих, буг дарах, газрын ам бооход сайн. Байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун хойд зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвидна.

## ӨНӨӨДӨР ЗЕНИТЧДИЙН БАЯРЫН ӨДӨР ТОХИОЖ БАЙНА

Зэвсэгт хүчний Цэргийг агаарын довтолгооноос эсэргүүцэн хамгаалах цэрэг үүсэн байгуулагдсаны түүхт 85 жилийн ой өнөөдөр тохиож байна. Түүхт ойг тохиолдуулан Зэвсэгт хүчний 326 дугаар ангид цэргийн ёслолын арга хэмжээ, баярын хурал, гурван үеийн зенитчдийн уулзалт болж байна. Түүхт ойг тохиолдуулан Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, хошууч генерал Б.Амгаланбаатар мэндчилгээ дэвшүүлжээ. Мэндчилгээнд "Орчин цагийн Зэвсэгт хүчинд цэргийг агаарын довтолгооноос хамгаалах

их үйлсэд эрдэм бүтээл, хөдөлмөр зүтгэлээ зориулсан эрхэм генерал, офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны дайчид, ажилтан алба хаагчид, ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэж байгаа зенитчид, бэлтгэл болон чөлөөнд байгаа дайчид Та бүхэндээ Цэргийг агаарын довтолгооноос эсэргүүцэн хамгаалах цэрэг үүсэн байгуулагдсаны түүхт 85 жилийн ойн мэндийг Хуурай замын цэргийн нийт бие бүрэлдэхүүний нэрийн өмнөөс болон хувиасаа өргөн дэвшүүлье!  
**Лүргэлжлэл нь арын нүүрт!**



## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2,272,557 /69.9%/	2,174,840 /66.8%/	1,033,548 31,8%
		116,029 /3,6%/

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
8435 +112	0	8314

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

<b>Тохиолдол</b>
Нийт: 494,215,914
<b>Эдгэрсэн</b>
Нийт: 429,807,346
<b>Нас барсан</b>
Нийт: 6,183,655

**ЭМД** Зүүлт мөнгөний гааргалын шимтгэлийг нь **ТӨР ХАРИУЦАН ТӨЛӨХ ҮРГЭД**

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2% -ЦАР

- Тэтгэвэрээ өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн
- Нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өргөн тусуун иргэн
- Хүүхдээ 2 дугаар рал 3 нас хүртэл нь өсгөн байжүүлж байгаа эцэг эх
- Хугацаат цэргийн албан хаагч
- Ил эрхэлж байгаа иргэн

сая 8,400Т 0-----100,800Т жилд

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1% -ЦАР

- 0-18 насны хүүхэд

сая 4,200Т 0-----50,400Т жилд

Та өөрийн ЭМД-ын шимтгэл төлөхийн мэдээлэлд байгаа газраасаа, холбооноо шалгалт болон мэдээлэл WWW.EMD.GOV.MN

Цахим шууданд

**ӨНӨӨДӨР ЗЕНИТЧДИЙН  
БАЯРЫН ӨДӨР ТОХИОЖ БАЙНА**

Түрүүч нь эхний нүүрт!



Зенитчдийн яруу алдар үүрд мөнх мандай бабарч, Монгол цэргийн сүлд хиймөр үргэлж босоо байг.

Зенитчин дайчид дайны хүнд жилүүдэд үүргээ нэр төртэй биелүүлэн өнөөдрийн энх цагийг бүтээлцэж, энх цагт ч эх орны бүтээн байгуулалт, хөгжил дэвшилд манлайлан оролцож, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг бэхжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулж яваа бахархам түүхтэйг баярын энэ өдөр бахдан дурсахаа таатай байна. Бид бүхний хамтдаа бүтээсэн амжилт бүхэн маань халуунд халж, хүйтэнд хөрж, зүтгэсэн ахмад үеийнхний маань үйл хэргийн залгамжлал, өнөөдөр эх орондоо тангараг өргөн эр цэргийн албанд мөр зэрэгцэн алба хааж байгаа байлдагчаас эхлээд ажил албандаа бүтээлчээр хандаж, ирээдүй өөд итгэлтэй тэмүүлсэн Цэргийг агаарын довтолгооноос

эсэргүүцэн хамгаалах цэрэг хэмээх алдрын эздийн нэгэн үзүүрт сэтгэл, зүтгэлийн үр бүтээл билээ. Түүхт баярын энэ өдөр гавьяа зүтгэл, шударга ариун хөдөлмөрийнхөө үнэлгээ болсон одон медалиараа гоёж, сэтгэл зүрх нь догдлон байгаа ахмад дайчдаа чин сэтгэлийн хүндэтгэл илэрхийлэн, урт насалж, удаан жаргахын ерөөл дэвшүүлье. Зэвсэгт хүчний Цэргийг агаарын довтолгооноос хамгаалах ариун жагсаалд орж, алтан шаргал нар, мөнх хөх тэнгэрийг сахин хамгаалах ашдын хүндтэй үүргийг хүлээсэн эрхэм зенитчдэдээ албанд нь амжилтын дээдийг хүсэн ерөөж, баярын мэндчилгээ дэвшүүлье. Эх орны минь тэнгэр цэлмэг, эрхэм зенитчдийн сум нь мэргэн байг" гэжээ.

**ХУВЦАСНЫ ҮЗЛЭГ ЯВУУЛАВ**



Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалын дагуу Хуурай замын цэргийн командлалын офицер, ахлагч нарын дулааны улирлын дүрэмт хувцасны үзлэгийг өнөөдөр зохион байгууллаа. Энэ нь ЗХЖШ-ын даргын 2019 оны А/595 дугаар тушаалаар

батлагдсан "Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм"-ийг бие бүрэлдэхүүнд мөрдүүлэх, жигдрэлтэд нь анхаарах, зөрчил дутагдлыг арилгуулах зорилготой юм. Мөн энэ үеэр албаны хувцасны мөрдэс, төмөр таних тэмдэг, сүүлд төгссөн сургуулийн энгэрийн тэмдэг,

байгууллагын хүндэт тэмдэг, цэргийн мэргэжлийн зэргийн тэмдэг, одон, медалийн тууз, хатгамал ялгах тэмдэг зэргийг нь шалгаж, бүрдүүлэлт нь дутуу зарим цэргийн алба хаагчдыг зөрчлөө арилгах талаар хугацаатай үүрэг өглөө.

**КОМАНДЛАЛЫНХАН МАРШ  
ҮЙЛДЭХ ЯВЦДАА БАЙГАЛЬ ОРЧНОО  
ЦЭВЭРЛЭЛЭЭ**

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын бие бүрэлдэхүүн 2021-2022 оны цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу тактик, тусгай бэлтгэлийн цогцолбор 30 км-ын явган марш үйлдлээ. Маршийг Төв аймгийн Зуунмод сумаас Төв аймгийн Сэргэлэн сум Дойтын ам, Ээж хайрхан гэсэн маршрутаар үйлдсэн бөгөөд энэ үед нийгмийн хариуцлагын хүрээнд хайрхны орчмын хогийг бүхэлд нь цэвэрлэж, байгаль орчноо цэмцэглэлээ. Энэ удаагийн марш нь бие бүрэлдэхүүний "Цугларалт" дохиогоор ажиллах дадлагыг нэмэгдүүлэх, албан тушаалтнуудыг гүйцэтгэх үүрэгт нь дадлагажуулах, бэлэн байдлыг дээшлүүлэх, цагийн байдлын ямар ч нөхцөлд тавигдсан үүргийг



Биелүүлэхэд сэтгэл зүйн болон бие бялдын бэлтгэл олгох зорилгоор зохион байгуулагдсан юм.

**ЦЭРГИЙН ЧУУЛГА УРАН  
БҮТЭЭЛЧДИЙН БЭЛЭН БАЙДЛЫН  
ҮЗЛЭГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА**



Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан ЦДБЭЧ-ын 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөө, Батлан хамгаалахын сайдын баталсан чуулгын "2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах, ЦДБЭЧ-ын түүхт 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд ЦДБЭЧ-ын даргын 2022 оны А/47 дугаар тушаалаар "Урлагийн бригадууд"-ын бэлэн байдлын үзлэгийг энэ сарын 05.06.07-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Тус үзлэг нь урлагийн бригадуудын бүрэлдэхүүний тоглолтын хөтөлбөрийг тодотгон, уран бүтээлчдийн ур чадвар, урын сангийн баяжилт, шинэ бүтээлүүдийн чанар, хүртээмж, тоглолтын найруулга, хувцас хэрэглэл, тайзны техникт үзлэг хийх зэрэг томоохон ач холбогдолтой юм. ЦДБЭЧ-ын даргын тушаалаар урлагийн бригадуудыг уран бүтээлчдийн бүтээлийн онцлогт тулгуурлан 3 хэсэгт хуваарилсан бөгөөд 1 дүгээр бригад нь "Эстрад симфони найрал хөгжим"-ийн бүрэлдэхүүнтэй цэрэг, эх орны сэдэвт

бүтээлүүдийг үзэгчдэд хүргэх, 2 дугаар бригад нь "Үндэсний хөгжим"-ийн бүрэлдэхүүнтэйгээр ардын урлаг, үндэсний уламжлалт урлагийг түгээн дэлгэрүүлэх, 3 дугаар бригад нь дуучид бүжигчдийн бүрэлдэхүүнтэйгээр орчин үеийн хэв маяг бүхий уран бүтээлүүдийг ард иргэд цэрэг дайчдад хүргэн сурталчлах юм. Тус үзлэгийн дараагаар ЦДБЭЧ-ын удирдлага, мэргэжлийн багш нар 3 бригадын үзлэгийн дүнг хэлэлцэн уран бүтээлийн чанар хүртээмж, урын сангийн баяжилт зэрэгт үнэлэлт дүгнэлт өгөх юм.

Шинэ ном

**"ХОВДЫН ДОМОГТ АДУУЧ ДАРГА"  
НОМ УНШИГЧДЫН ГАРТ ОЧЛОО**

Ийм нэгэн содон нэртэй ном 800 гаруй хувь хэвлэгдэн уншигчдын гарт очлоо. Монгол Улсын Ардын багш, гавьяат дасгалжуулагч Адуучийн Басхүү хайрт аавынхаа гэгээн дурсгалд зориулан бичсэн эл ном "Аав минь эх орноо батлан хамгаалах ариун үйлст зүтгэсэн нь", "Аав минь Алтай нутгийнхаа энхийг бүтээн байгуулалтын үйлсийг оройлон зүтгэсэн нь", "Төрдөө нэртэй, түмэндээ нүүртэй аав, ээжийн минь далайн буяан", "Аавыг минь ховдчууд матаагүй, мартах учиргүй" гэсэн 4 бүлэгтэй аж. Энэхүү ном нь эх орон, улс нийгэм, нутаг ус, байгууллага хамт олондоо алдар хүндтэй, хийж бүтээсэн бүхэн нь газар дэлхий дээр сүндэрлэж, хүмүүний сэтгэл зүрхэнд мөнхөрч



аавынхаа тухай бичсэн нь үр хүүхдийнхээ нь байтугай сум аймгийн хэмжээнээс хальж хэний боловч бахархлыг төрүүлж хэнд ч болов дуурайл болох нэгэн үнэт бүтээл болжээ. Түүнчлэн хүү нь аавынхаа тухай гэсэн хэдий ч аавынхаа тухай гэхээс илүүтэй тунгалаг Буянтаараа овоглосон олон ястны өлгий нутаг Ховдчууд, баатарлаг дайчин уламжлалтай Булганчууд, торгууд түмний өнгөрсөн цаг хугацаанд олсон ололт амжилт, бүтээн байгуулалт, ард түмний хөдөлмөр, тэмцлийн түүхийг

бага боловч дурсан өгүүлжээ. Мөн аавынхаа анд нөхөд, удирдлагын нь дор ажиллаж байсан бүхий л хамт олны тухай дурсан тэмдэглэхээс гадна Адууч гэх хүний эх орныхоо тусгаар тогтнол, газар нутаг, дархан хилээ батлан хамгаалахын төлөө, улс орон, аймаг сумаа хөгжүүлэх, өнөөдрийн эрх чөлөөт майн сайхан амьдралын төлөө бие сэтгэл зүрхээ зориулан зүтгэсэн хөдөлмөрийн түүхэн замнал, бодит үйл хэргийг хойч үедээ бичиж үлдээсэн томоохон уран бүтээл болжээ.